



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 368

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эдийн засаг, хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 54,400,000.00 (тавин дөрвөн сая дөрвөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 38,090,880.30 (гучин найман сая ерэн мянга найман зуун наян төгрөг гучин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн бичгийн дарга Х.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

137001801
17-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
368 дугаар тогтоолын хавсралт

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМАНД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛ

д/д	Автомашини нэр, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон ОН	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Хюндай Элантра, улсын дугаар- 0374 УНУ, арлын дугаар- KMND741CBVLU064121	2020	54,400,000.00	38,090,880.30	16,309,119.70
	Нийт дүн		54,400,000.00 (тавин дөрвөн сая дөрвөн зуун мянга)	38,090,880.30 (гучин найман сая ерэн мянга найман зуун наян төгрөг гучин мөнгө)	16,309,119.70 (арван зургаан сая гурван зуун есөн мянга нэг зуун арван есөн төгрөг далан мөнгө)